

АГУУЛГА

|                                                                                                                                                                 |    |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| БҮЛЭГ 1. ТУХАЙН ОРДЫН УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....                                                                                           | 3  |
| 1.1 Ордын байршил .....                                                                                                                                         | 3  |
| 1.2 Ордын геологийн тогтоц .....                                                                                                                                | 4  |
| 1.3 Геологийн нөөц.....                                                                                                                                         | 5  |
| 1.4 Уулын ажлын одоогийн төлөв .....                                                                                                                            | 6  |
| БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....                                                                                  | 7  |
| БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....                                                                                                          | 10 |
| БҮЛЭГ 4. БИОЛОГИЙН БОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ, ТЭРБУМ МОДНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....                                                | 11 |
| БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....                                                                      | 13 |
| БҮЛЭГ 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....                                                                                 | 13 |
| БҮЛЭГ 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....                                                                                               | 14 |
| БҮЛЭГ 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....                                                                                                 | 17 |
| БҮЛЭГ 9. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....                                                                                                 | 19 |
| БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....                                                                                                    | 20 |
| 10.1. Хөрсний шинжилгээ .....                                                                                                                                   | 20 |
| 10.2. Усны шинжилгээ .....                                                                                                                                      | 20 |
| 10.3. Агаарын шинжилгээний дүн.....                                                                                                                             | 21 |
| БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..                               | 22 |
| БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... | 23 |
| ДҮГНЭЛТ .....                                                                                                                                                   | 25 |
| Хавсралт .....                                                                                                                                                  | 26 |

### Зургийн жагсаалт

|                                                                                          |    |
|------------------------------------------------------------------------------------------|----|
| Зураг 1. Баянгол суманд хэрэгжүүлэх тэрбум мод хөтөлбөр хэрэгжүүлэх талбайн байршил..... | 11 |
| Зураг 2. Тэрбум мод үндэсний хүрээнд мод тарив.....                                      | 12 |

### Хүснэгтийн жагсаалт

|                                                                                                                                                                          |    |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд .....                                                                                                             | 3  |
| Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт .....                                                                                         | 7  |
| Хүснэгт 3. Суулгах модны хэмжээ, зардал .....                                                                                                                            | 11 |
| Хүснэгт 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....                                                                                                      | 14 |
| Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....                                                                                                         | 17 |
| Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....                                                                                                         | 19 |
| Хүснэгт 7. Хөрсний шинжилгээний үр дүн .....                                                                                                                             | 20 |
| Хүснэгт 8. Усны шинжилгээний үр дүн.....                                                                                                                                 | 20 |
| Хүснэгт 9. Уурхайн талбайн агаарын чанар, дуу шуугианы хэмжилт .....                                                                                                     | 21 |
| Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт .....                                                                                                    | 22 |
| Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөх оршин суугчид олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт ..... | 24 |
| Хүснэгт 12. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн зардлын нэгтгэл .....  | 25 |

## БҮЛЭГ 1. ТУХАЙН ОРДЫН УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Ордын байршил

Бороо-7, 41/42 алтны үндсэн орд нь засаг захиргааны хувьд Сэлэнгэ аймгийн Баянгол сумын баруун өмнөд хэсэгт орших бөгөөд Улаанбаатар хотоос хойш 130 км, Баянгол сумаас баруун урагш 15 км зайд оршино. Талбайн номенклатурын хувьд М-48-117 планшетэд байрлана.


Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших “Бороо” нэртэй XV-008947 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг анх АМХЭГ-ын ГУУКА-наас 2004 оны 12 дугаар сарын 14-ний өдөр АМХЭГ-ын ГУУКА-наас хайгуулын ажил гүйцэтгэх эрхийг нийт 11002.68 га талбайд олгосон байдаг.

2009 оноос Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж эхэлсэн “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон тусгай зөвшөөрөлтэй талбайн зарим хэсэг усны эх бүрэлдэх хэсэгтэй давхацсан тул тус хуулийн дагуу талбайгаас хасалт хийлгэсэн байна.

Үүний дараа MV-017548 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын КХ-ийн даргын тушаалаар 2014 оны 06-р сарын 04-ний өдөр олгосон байдаг. Ордын төв цэгийн газарзүйн солбицол нь уртрагийн 106°4'10.83", өргөргийн 48°47'1.02"-д байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 574.98 га талбайг хамарна. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбицлыг хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд

| №  | MV-017548      |                |           |
|----|----------------|----------------|-----------|
|    | Уртраг         | Өргөрөг        | Талбай    |
| 1  | 106° 5' 15.47" | 48° 47' 57.88" | 574.98 га |
| 2  | 106° 4' 27.9"  | 48° 47' 57.88" |           |
| 3  | 106° 4' 27.9"  | 48° 47' 12.8"  |           |
| 4  | 106° 2' 58.7"  | 48° 47' 12.8"  |           |
| 5  | 106° 2' 58.7"  | 48° 46' 53.7"  |           |
| 6  | 106° 2' 28.9"  | 48° 46' 53.7"  |           |
| 7  | 106° 2' 28.9"  | 48° 46' 19.27" |           |
| 8  | 106° 3' 12.6"  | 48° 46' 19.27" |           |
| 9  | 106° 3' 12.6"  | 48° 46' 37.1"  |           |
| 10 | 106° 5' 43"    | 48° 46' 37.1"  |           |
| 11 | 106° 5' 43"    | 48° 47' 7.01"  |           |
| 12 | 106° 5' 15.47" | 48° 47' 7.01"  |           |



### **Бүс нутгийн мэдээлэл, хүн ам, эдийн засгийн байдал**

Сэлэнгэ аймгийн Баянгол сум нь 197.6 мян.га газар нутагтай, Сүхбаатар хотоос 170 км, Улаанбаатар хотоос 156 км, урд талаараа Төв аймгийн Сүмбэр сум, зүүн талаараа Сэлэнгэ аймгийн Мандал сумтай, хойд талаараа Дархан-Уул аймгийн Хонгор сум, Шарын гол сумтай хиллэдэг, Улаанбаатар, Дархан, Сэлэнгэ чиглэлийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг мөн төмөр замын зангилаатай. Төсвийн 10 байгууллага, 3 баг, 5600 гаруй хүн ам, 138.8 мянга гаруй толгой мал, 1636 айл өрхтэй.

**Газар зүй:** Орд нь Хэнтийн уулархаг мужийн баруун захад оршдог бөгөөд тус бүс нутгийн хэмжээнд Хараа, Бороо, Загдал, Зуун мод голын усан хагалбар болох янз бүрийн чиглэлээр сунаж тогтсон, хагас ойжсон уул нурууд ихтэй. Талбайн үнэмлэхүй өндөржилт нь Зүрхийн Овоо 1363.2 м, Чандагатай 1336.8 м зэрэг уулс бөгөөд уулсын хормой нь салхины гаралтай алтан хэмэрлэг элсээр хучигдсан байдаг. Районы хувьд усан сүлжээ сайн хөгжсөн, уулс нуруудын хооронд Хараа гол, Бороо гол, тэдгээрийн цутгалууд болон хөндий, гол, горхи зонхилно. Бүс нутгийн хэмжээнд усан сүлжээ сайн хөгжсөн боловч ордын талбайд гол, горхи ховор, талбайн баруун хэсэгт Хавчуугийн амны горхи, зүүн хэсгээр Бороо гол урсан өнгөрдөг.

**Уур амьсгал:** Байгаль цаг уурын хувьд зөөлөн уур амьсгалтай, газар тариалан мал аж ахуй эрхлэхэд таатай нөхцөлтэй. Зундаа +20°C, өвөлдөө -20° ~ -40°C хооронд хэлбэлзэнэ. 7-9 саруудад болон өвлийн улиралд 15-20 см зузаантай зарим тохиолдолд түүнээс их хур тунадас ордог. Сүүлийн жилүүдэд цаг уурын өөрчлөлтөөр хуурайшилт их явагдаж байна.

**Хөрс, ургамал зүй:** Ордын талбайн хувьд дөрөвдөгчийн сэвсгэр хурдах ихээхэн тархалттай, өвс ургамлаар битүү бүрхэгдсэн. Талбайн хувьд ой мод багатай, ерөнхийдөө нүцгэн, хагас мөлгөрдүү оройтой уулс зонхилдог. Бороо голын хөндийгөөр бургас элбэг ургана.

### **1.2 Ордын геологийн тогтоц**

Ордын талбай нь МУ-ын тектоникийн мужлалаар вендийн настай Дархан террейн, Хангай-Хэнтийн эх газрын захын тэнгисийн Хэнтийн супер террейнүүдийн зааг орчмын бүс нутгийг эзлэн оршдог ба голлох хурдас чулуулгууд нь палеозойн насны хувирмал, тунамал чулуулаг, кайнозойн сэвсгэр хурдас юм. Энэ хурдас хуримтлал нь түрүү палеозой, мезозойн боржин, цахирт диорит, диоритын найрлагатай интрузив чулуулгаар зүсэгджээ.

**Дунд кембрий-доод ордовик** Хараа группийн (E2-O1hr) хурдас нь зүүн хойшоо суналтай, томоохон синклинори тогтцыг үүсгэн байрлана. Уг хурдас нь Бороо голын ба Их дашрын гүний ба хагас гүний биетүүдээр зүсэгдэн, хил заагийн термаль метаморфизмд хүчтэй автагдан гнейс, роговик, мигматит болтлоо хувирсан байдаг. Мөн зарим газарт гүний цулуудын дээвэр хэсэгт томоохон үлдэгдэл байдлаар байрлах тул түүнийг бүрдүүлэгч элсэн чулуу, алевролит, шаварлаг занарууд нь хүчтэйгээр метаморфизмд өртсөн байдаг. Талбайд тархсан энэхүү хурдас нь элсэн чулуу голлосон элсэн чулуу-шаварлаг занарын гэсэн нийцлэг байрлалтай дээд, доод хоёр зузаалагт хуваагдах ба зүүн хойш чиглэлтэй томоохон хэмжээний хөнтрүү синклиналь атирааг үүсгэн тогтдог байна.

**Плиоцен-доод плейстоцены хуримтлал** (N2-Q1) нь ихэнхдээ газрын гадарга дээр илэрдэггүй боловч бараг бүх томоохон хөндий, түүний цутгалуудад дээд плейстоцен, голоцены сэвсгэр хурдасны дор дарагдмал байдлаар орших ба бэл хормойн гаралтай, хялбар бутлагдах янз бүрийн хэмжээ, найрлагатай хэмхдэс материал, хайрганцар агуулсан улаан, улаан хүрэн өнгийн шавар, шавранцраас тогтоно. Зузаан 35-45 м.

**Дөрөвдөгчийн тогтолцоо.** Дөрөвдөгчийн хурдас нь талбайд өргөн тархалттай бөгөөд томоохон хөндий түүний цутгал амууд, уулын бэл хормой, гуу жалганд хуримтлагдана: дээд плейстоцен-голоцен, голоцены гэсэн хоёр насанд ялгасан байна. Хурдасны зузаан төрлөөс хамаарч 5-35~40 м.

### **Бороо- 41/42 алтны үндсэн ордын геологийн тогтоц**

Илрэлийн хэмжээнд олон тооны кварцын судлууд тогтоогдсоноос /0.7 м<sup>2</sup> талбайд/ Бороо-41/42-р судлууд нь харьцангуй сайн судлагдсан бөгөөд тэдгээр нь зэрэгцээ байдлаар оршдог. Талбайд олон тооны баруун хойд чиглэлийн хагарлуудтай, хагарлуудаар багахан хэмжээний шилжилтүүд үүссэн, зүүн хойд, зүүн чиглэлийн хагарлуудаар босоо чиглэлийн суулт, өргөгдөл явагдсан байдаг.

Бороо-41/42 алтны ордын хэмжээнд гүйцэтгэсэн эрэл-үнэлгээний ажлын үр дүн алт агуулсан 3

хүдрийн биетийг олж тогтоон 1 ба 2-р хүдрийн биетийн хүрээнд урьдчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэсэн болно.

### **Бороо-7 ордын геологийн тогтоц**

Сэлэнгэ минералс ХХК нь 2013 оны хайгуулын үед тус ордын хэмжээнд эрэл үнэлгээ ба урьдчилсан хайгуулын шатны ажил хийж ордын ба ордын гол хүдрийн биетийн хэмжээнд 1:2000, 1:1000 масштабын геологийн зураглалын ажил гүйцэтгэн алтны хүдэржилт агуулсан бүсүүдийн хил заагийг тогтоон зурагласан юм. Энэ ажлын үр дүнд тулгуурлан хүдрийн биетүүдийг нээн сорьцлох зорилгоор 673 м<sup>3</sup> суваг нэвтрэлт, 1238 т.м өрөмдлөгийн ажил гүйцэтгэн, нийт 28 ш ховилон сорьц, 213 ш керний сорьц авч шинжилгээнд хамруулсан болно.

Бороо-7 ордын хэмжээнд өмнөх судлаачд болон Сэлэнгэ минералс ХХК-ний ажлын үр дүнд Бороо-7 гол хүдрийн биет, Бороо-7А, Бороо-7В, Бороо-7С, Бороо-7D, Бороо-7Е8, Бороо-7F зэрэг 7 хүдрийн биетийг тогтоож биетүүд нь ямар нэг хэмжээгээр хууль бус алт олборлогчдын үйл ажиллагаанд өртсөн байна. Бороо-7 ордын эдгээр хүдрийн биетүүдээс Гол хүдрийн биетийн хэмжээнд урьдчилсан хайгуулын ажлыг гүйцэтгэн үнэлгээ өглөө.

### **1.3 Геологийн нөөц**

Бороо-7, Бороо41/42 ордод 2004-2013 онуудад хайгуулын ажил гүйцэтгэсэн ба хайгуулын ажлын үр дүнд Бороо-41/42 ордын 1-р хүрийн биетийн 1.13 гр/тн дундаж агуулгатай 187.25 мян.тн хүдэр дэх 193.9 кг /химийн цэврээр/ алтны нөөцийг эдийн засгийн үр ашигтай нөөц, харин Бороо-41/42 ордын 2-р хүрийн биетийн 1.44 гр/тн дундаж агуулгатай 167.0 мян.тн хүдэр дэх 220.7 кг /химийн цэврээр/ алт болон Бороо-7 ордын гол хүрийн биетийн 3.14 гр/тн дундаж агуулгатай 116.9 мян.тн хүдэр дэх 337.9 кг /химийн цэврээр/ алтны нөөцийг тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай нөөцөөр тогтоон АМГ-ын даргын 2014 оны 04-р сарын 01-ний өдрийн Н- 51 тоот тушаалаар ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

Улмаар 2014 онд зөвхөн Бороо-7 ордын хэмжээнд нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэж нөөцийн тодотгол тайлан боловсруулжээ. Ингэснээр Бороо-7 ордод бодитой болон боломжтой В+С зэргээр 2.38 гр/тн дундаж агуулгатай 136.5 мян.тн хүдэр дэх 324.5 кг /химийн цэврээр/ алтны нөөцийг АМГ-ын даргын 2015 оны 06-р сарын 05-ний өдрийн Н-63 тоот тушаалаар ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

**Хүснэгт 3-2. Ордын геологийн нөөц /2014 онд АМГ-ын даргын Н-51 тоот тушаалаар хүлээн авсан/**

| Нөөцийн ангилал                                | Орд                                  | Нөөцийн зэрэг | Блокийн дугаар | Эзлэхүүн жин, тн/м <sup>3</sup> | Хүдэр, тн      | Дундаж агуулга, гр/тн | Металл, кг    | Металл, кг /химийн цэврээр/ | Тайлбар                                                                                                                              |
|------------------------------------------------|--------------------------------------|---------------|----------------|---------------------------------|----------------|-----------------------|---------------|-----------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Эдийн засгийн үр ашигтай нөөц                  | Бороо 41/42 ордын 1-р хүдрийн биет   | В             | I-B-2          | 2.60                            | 76,898         | 1.13                  | 87.08         | 80.12                       | Энэхүү ТЭЗҮ-ийн тодотголд ил аргаар ашиглахаар тусгасан.                                                                             |
|                                                |                                      | С             | I-C-1          | 2.60                            | 61,173         | 1.33                  | 81.06         | 74.58                       |                                                                                                                                      |
|                                                |                                      |               | I-C-2          | 2.60                            | 30,283         | 1.06                  | 32.25         | 29.67                       |                                                                                                                                      |
|                                                |                                      |               | I-C-3          | 2.60                            | 18,897         | 0.55                  | 10.37         | 9.54                        |                                                                                                                                      |
|                                                |                                      | <b>В+С</b>    | <b>Нийт</b>    | <b>2.60</b>                     | <b>187,251</b> | <b>1.13</b>           | <b>210.76</b> | <b>193.90</b>               |                                                                                                                                      |
| Тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай нөөц | Бороо 41/42 ордын 2-р хүдрийн биет   | В             | II-B-1         | 2.60                            | 59,675         | 1.38                  | 82.30         | 75.72                       | Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврын дагуу олборлолтод өртөхгүй.                                                   |
|                                                |                                      | С             | II-C-1         | 2.60                            | 97.97          | 1.51                  | 148.03        | 136.19                      |                                                                                                                                      |
|                                                |                                      |               | II-C-2         | 2.60                            | 9,433          | 1.01                  | 9.56          | 8.79                        |                                                                                                                                      |
|                                                |                                      |               | <b>Нийт</b>    | <b>2.60</b>                     | <b>167,077</b> | <b>1.44</b>           | <b>239.89</b> | <b>220.70</b>               |                                                                                                                                      |
|                                                | Бороо 7 ордын гол хүдрийн биет       | С             | I-C-1          | 2.60                            | 75,556         | 2.09                  | 158.77        | 146.07                      | Нэмэлт хайгуулын ажлаар нөөцийн зэрэг ахиулсан. /АМГ-ын даргын 2015 оны 06 сарын 05-ний Н-63 тушаалаар энэ хэсгийн нөөцийг цуцалсан/ |
|                                                |                                      |               | I-C-2          | 2.60                            | 41.35          | 5.04                  | 208.58        | 191.89                      |                                                                                                                                      |
|                                                |                                      | С             | <b>Нийт</b>    | <b>2.60</b>                     | <b>116,906</b> | <b>3.14</b>           | <b>367.35</b> | <b>337.96</b>               |                                                                                                                                      |
|                                                |                                      |               |                |                                 |                |                       |               |                             |                                                                                                                                      |
| Бороо-41/42 болон Бороо-7 ордын нийт           | Бороо-41/42 болон Бороо-7 ордын нийт | <b>В+С</b>    | <b>Нийт</b>    | <b>2.60</b>                     | <b>283,983</b> | <b>4.58</b>           | <b>607.24</b> | <b>558.66</b>               |                                                                                                                                      |
|                                                |                                      | В             | Нийт           | 2.60                            | 136,573        | 1.24                  | 169.38        | 155.83                      |                                                                                                                                      |
|                                                |                                      | С             | Нийт           | 2.60                            | 334,661        | 1.94                  | 648.62        | 596.73                      |                                                                                                                                      |
|                                                |                                      | <b>В+С</b>    | <b>Нийт</b>    | <b>2.60</b>                     | <b>471,234</b> | <b>1.74</b>           | <b>818.00</b> | <b>752.56</b>               |                                                                                                                                      |


Хүснэгт 3-3. Ордын геологийн нөөц /2015 онд АМГ-ын даргын Н-63 тоот тушаалаар хүлээн авсан/

| Хүдрийн биет     | Нөөцийн зэрэг | Блокийн дугаар | Эзлэхүүн жин, тн/м³ | Хүдэр, тн | Дундаж агуулга, гр/тн | Металл, кг | Металл, кг /химийн цэврээр/ | Тайлбар                                                    |
|------------------|---------------|----------------|---------------------|-----------|-----------------------|------------|-----------------------------|------------------------------------------------------------|
| 1-р хүдрийн биет | B             | I-B-1          | 2.77                | 58,516    | 1.59                  | 92.86      | 85.43                       | Энэхүү ТЭЗҮ-ийн тодотголд ил аргаар ашиглахаар тусгасан.   |
|                  | C             | I-C-1          | 2.77                | 18,055    | 1.47                  | 26.53      | 24.41                       |                                                            |
| Нийт             | /B+C/         |                | 2.77                | 76,571    | 1.53                  | 119.39     | 109.84                      |                                                            |
| 2-р хүдрийн биет | B             | II-B-1         | 2.77                | 57,9790   | 3.49                  | 202.50     | 186.30                      | Энэхүү ТЭЗҮ-ийн тодотголд далд аргаар ашиглахаар тусгасан. |
|                  | C             | II-C-1         | 2.77                | 1,196     | 1.56                  | 1.88       | 1.73                        |                                                            |
|                  |               | II-C-2         | 2.77                | 774       | 0.96                  | 0.75       | 0.69                        |                                                            |
| Нийт             | /B+C/         |                | 2.77                | 59,949    | 3.42                  | 205.13     | 188.72                      |                                                            |
| Нийт             | B             |                | 2.77                | 116,495   | 2.54                  | 295.36     | 271.73                      |                                                            |
|                  | C             |                | 2.77                | 20,025    | 1.46                  | 29.16      | 26.83                       |                                                            |
|                  | /B+C/         |                | 2.77                | 136,520   | 2.38                  | 324.52     | 298.56                      |                                                            |

#### 1.4 Уулын ажлын одоогийн төлөв

Бороо-7, Бороо-41/42 ордод 2004-2014 онуудад, мөн 2015 онд хайгуулын ажил гүйцэтгэн ордын нөөцийг тогтоосон боловч одоог хүртэл ордод олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй байна.

“Сэлэнгэ Минералс” ХХК нь Бороо-7 ордод 1-р хүдрийн биетийг олборлох ил уурхайд хөрс хуулалтын ажил гүйцэтгэсэн. Харин 2-р хүдрийн биетэд хууль бус алт олборлогчид далд уурхайн налуу малталт нэвтэрсэн байдалтай байна. Уурхайн одоогийн байдлыг дараах зурагт харууллаа.



Ил уурхайд одоогийн байдлаар +1110, +1120, +1131, +1108 зэрэг түвшнүүдэд хөрс хуулалтын ажил гүйцэтгэсэн байдалтай байна.


Далд уурхайд хуувьд Бороо-7 ордын 2-р хүдрийн биетэд налуу малталт нэвтэрсэн байна. Малталтын уртраг Y-5403945, малталтын өргөрөг X-579171, малталтын өндөржилт +1092 метр байна.

## БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлсон. Уурхайн үйл ажиллагааны явцад гарах эрсдэл ослоос урьдчилсан сэргийлэх, дагаж мөрдөх шаардлагатай тул тэмдэг тэмдэглэгээг байршуулахаар төлөвлөсөн.

### Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Байгаль орчныг хамгаалахад хэрэгжүүлсэн арга хэмжээ                                                                                                                                        | Хамарсан цар хүрээ    | Хэм<br>жих<br>нэгж | Хэмжээ | Нэгжийн<br>үнэлгээ<br>/төг/ | Нийт<br>зардал<br>/мян.төг/ | Тайлбар                                                | Хэрэгжүүлсэн хувь |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|--------------------|--------|-----------------------------|-----------------------------|--------------------------------------------------------|-------------------|
| Агаарын чанар                                                                                                                                                                              |                       |                    |        |                             |                             |                                                        |                   |
| Уурхайн бүх машин механизмд үзлэг оношилгоо хийлгэх                                                                                                                                        | Уурхайн бүх автомашин | ш                  | 5      | -                           | 500 000                     | Машин механизмын үйл ажиллагаа явагдаагүй.             | 100               |
| Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх, тоос дарагч бодис ашиглах                                                                                   | Уурхайн талбай        | -                  | -      | -                           | 800 000                     | Шаардлагатай үед зам усалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100               |
| Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах | ШТС                   | -                  | -      | -                           | 250 000                     | Саармагжуулах багаж хэрэгслийг бэлэн байлгаж байна.    | 100               |
| Гадаргын ба газрын доорх усны нөөц                                                                                                                                                         |                       |                    |        |                             |                             |                                                        |                   |

|                                                                                                            |                             |          |    |          |          |                                                                                     |     |
|------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------|----------|----|----------|----------|-------------------------------------------------------------------------------------|-----|
| Ус ашиглах дүгнэлтийг гаргуулах.                                                                           | Төслийн хүрээнд             | -        | -  | 1716 000 |          |  | 100 |
| Ус ашиглах гэрээг Сэлэнгэ аймгийн БОГ-тай байгуулах.                                                       | Төслийн хүрээнд             | -        | -  | ҮАЗ      |          |  | 100 |
| Тухайн жил уурхайгаас шавхан зайлуулсан усны төлбөрийг гэрээ болон ус ашиглах дүгнэлтэд заасны дагуу төлөх | Төслийн хүрээнд             | мян. төг | -  | ҮАЗ      |          | Төлбөр тооцоог хийнэ.                                                               | 100 |
| Шүүрлийн усны шавхан зайлуулалтад хяналт тавьж ажиллах                                                     | Далд уурхай                 | -        | -  | 2000 000 |          | Шүүрлийн ус ялгараагүй.                                                             | 100 |
| Хөрсөн бүрхэвч                                                                                             |                             |          |    |          |          |                                                                                     |     |
| Уурхайн хогийн цэг, бие засах газруудад ариутгал халдваргүйжүүлэлт хийх                                    | Хогийн цэг, бие засах газар | ш        | 12 | 12 000   | 144 000  | Ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн                                                   | 100 |
| Дотоод тээврийн замыг услах                                                                                | Дотоод зам                  | Ш        | -  | -        | 4000 000 | -                                                                                   | 100 |

|                                                                                                 |                 |            |    |        |          |                                                                                                                                      |     |
|-------------------------------------------------------------------------------------------------|-----------------|------------|----|--------|----------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Засварын цех, ШТМ-ын агуулах, хуучин тос хадгалах цэг, ШТС зэргийн талбайг засаж сайжруулж байх | Төслийн талбайд | ш          | 10 | 20 000 | 2000 000 |  <p>Засаж, сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> | 100 |
| Нийт                                                                                            |                 | 11 410 000 |    |        |          |                                                                                                                                      | 100 |


### БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн жилд биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

#### БҮЛЭГ 4. БИОЛОГИЙН БОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ, ТЭРБУМ МОДНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд ЗДТГ-ын арын авто замын уулзвараас Баян 2-р багийн Дээжийн 1-р хэсэг авто пүү хүртэлх авто замын уулзвар хүртэл замын 2 талаар мод тарихаар төлөвлөсөн.

**Зураг 1. Баянгол суманд хэрэгжүүлэх тэрбум мод хөтөлбөр хэрэгжүүлэх талбайн байршил**



Сэлэнгэ минералс ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт байрлах Бороо 7, 42 алтны үндсэн ордын тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд нийт 9535 000 төгрөг зарцуулсан.

#### Хүснэгт 3. Суулгах модны хэмжээ, зардал

| Материалын нэр                                                                                       | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ, төг | 1 жилийн нийт үнэ, мян.төг | тайлбар                                                                                                                                                                               |
|------------------------------------------------------------------------------------------------------|-------------|------------|---------------|----------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Тэрбум модны хүрээнд орон нутгийн заасан талбайд мод тарих 0.8-1.2 м өндөртэй 2-3 настай хайлаас мод | ш           | 1600       | 5000          | 8000.0                     | ЗДТГ-ын арын авто замын уулзвараас Баян 2-р багийн Дээжийн 1-р хэсэг авто пүү хүртэлх авто замын уулзвар хүртэл замын 2 талаар мод тарина. Усалгааны зардлыг сум орон нутаг хариуцна. |
| Тарилтын хөлс                                                                                        | ш           | 1600       | 950           | 1535.0                     |                                                                                                                                                                                       |
| Нийт                                                                                                 |             |            |               | 9535.0                     |                                                                                                                                                                                       |

Зураг 2. Тэрбум мод үндэсний хүрээнд мод тарив



## **БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Сэлэнгэ минералс” ХХК-ийн “Бороо-7, Бороо-41/42 алтны үндсэн орд газрыг ашиглах” төсөл”-ийн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн “MV-017548” дугаартай талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх энэ жилдээ байхгүй. Уурхай нь үйл ажиллагаа явуулж дууссаны дараа уурхайн хаалт болон нүүлгэн шилжүүлэлт хийгдэнэ.

## **БҮЛЭГ 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Тусгай зөвшөөрлийн талбайд түүх соёлын дурсгалт зүйлс байхгүй тул үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй. Далд аргаар жонш олборлох ажлын явцад урьд өмнө үл мэдэгдэж байсан археологийн олдвор эсвэл түүх соёлын дурсгалт зүйлийг нээсэн тохиолдолд тус газрыг шалгаж үзтэл түүний ойр хавьд ямар ч төрлийн үйл ажиллагаа явуулалгүй уулын ажлыг зогсоох бөгөөд даруй мэргэжлийн байгууллагад хандах арга хэмжээ авч ажиллана.

## БҮЛЭГ 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдэлийг гаргахгүй байх юм. Иймээс уурхай нь 2025 онд аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн. Мөн уурхайн кемпэд галын аюулгүй байдлын хор байршуулахаар төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 1100 000 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

### Хүснэгт 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

| Байгаль орчныг хамгаалахад хэрэгжүүлсэн арга хэмжээ                              | Хамарсан цар хүрээ                              | Хэмжих нэгж | Хэмжээ | Нэгжийн үнэлгээ төг/             | Нийт зардал /мян.төг/ | Тайлбар                                                                                                                                                 | Хэрэгжүүлсэн хувь |
|----------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------|-------------|--------|----------------------------------|-----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------|
| <b>Хөдөлмөр хамгаалал</b>                                                        |                                                 |             |        |                                  |                       |                                                                                                                                                         |                   |
| Ажилчдыг хөдөлмөр хамгаалалтын хэрэгслээр хангаж ажиллах                         | Бүх ажилчид                                     |             |        | Үйл ажиллагааны зардал тусгасан. |                       | Ажилчдыг хөдөлмөр хамгаалалтын хэрэгслээр хангаж ажиллаж байна.<br> | 100               |
| Ажил эхлэхээс өмнө хөдөлмөр хамгааллын заавар зөвлөгөөг өдөр бүр өгч байх        | Нийт ажилчид                                    |             |        | Үйл ажиллагааны зардал тусгасан  |                       | ХААБ мэргэжилтэн тогтол заавар зөвлөгөөг өгч ажиллаж байна.                                                                                             | 100               |
| <b>Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх</b>                                  |                                                 |             |        |                                  |                       |                                                                                                                                                         |                   |
| Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын | Уурхайн тосгон<br>Тэсрэх материалын агуулах ШТС |             | 2      | 2000 000                         |                       | Аюулгүй байдлыг үүднээс шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллаж байна.                                                                                | 100               |

|                                                                                                                                                                      |                                              |   |   |                        |                                                                                                                       |     |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------|---|---|------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, түүний бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах. |                                              |   |   |                        |                                                                                                                       |     |
| Тэсрэх материалын болон ШТС-ын агуулахын эргэн тойрон дахь өвс ургамлыг зулгааж аюулгүйн зурвас татах                                                                | Уурхайн тосгон Тэсрэх материалын агуулах ШТС |   | 2 | 1000 000               |  <p>Аюулгүйн зурвас татсан.</p>    | 100 |
| <b>Байгалийн аюул гамшиг</b>                                                                                                                                         |                                              |   |   |                        |                                                                                                                       |     |
| Байгалийн аюул гамшиг, аваар осол, гал түймрийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах                                                              | -                                            | - | - | 2000 000               | Ажиллагсдад байгалийн аюул гамшиг, аваар осол, гал түймрийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан. | 100 |
| <b>Тэсрэх материалын агуулах</b>                                                                                                                                     |                                              |   |   |                        |                                                                                                                       |     |
| Уурхайн тэсэлгээний ажлыг явуулахдаа тэсрэх материалтай харьцах, тэсрэх бодис тээвэрлэх,                                                                             | Тэсрэх материалын агуулах болон              | - | - | Үйл ажиллагааны зардал | Тэсэлгээ хийх бүрд шаардлагатай арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллаж байна.                                         | 100 |

| хадгалах, хураах, устгах ажиллагаанд мөрдөж ажиллах                                                  | тэсэлгээ хийх бүрд         |   |   |                        |                                                |     |
|------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------|---|---|------------------------|------------------------------------------------|-----|
| Тэсэлгээний ажлыг мэргэжлийн үнэмлэх бүхий урд нь тэсэлгээ хийж байсан туршлагатай хүмүүсээр хийлгэх | Тэсэлгээний ажил хийх бүрд | - | - | Үйл ажиллагааны зардал | Тэсэлгээний ажлыг мэргэжлийн хүнээр хийлгэдэг. | 100 |
